АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН 2020 ОНЫ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Гүйцэтгэлийн зорилт | Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хүрэх төвшин | Хэрэгжилт, Хүрсэн түвшин | ХШҮСХ-ийн үнэлгээ |
|---|---|---|---|---|
| *1* | *2* | *3* | *4* | *6* |
| *НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ* | | | | |
| 1.1.5. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд илрүүлнэ. | 1.1.5.1. Гэрээлэгч компаниудын 2020 оны хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг хянах, мэргэжлийн санал дүгнэлт гарган батлуулах | Төлөвлөгөө, төсвийг хянан, санал дүгнэлт гарган батлуулсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 10 талбайд 2020 онд хийгдэх газрын тосны болон метан хийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан. | |
| | 1.1.5.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, дүгнэх, батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд хяналт тавих | Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцсэн байна.<br>Бүтэн жилд: 100% | Газрын тосны хайгуулын 17 талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг гаргасан. Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн А/85 дугаар тушаалаар гэрээний хэрэгжилт хангалтгүй 5 гэрээг цуцалсан. Хайгуулын 2 талбайд 4 мэргэжилтэн нийт 44 хоног хээрийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан удирдлагыг тухай бүр мэдээллээр хангасан. | |
| 1.1.6. Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлнэ. | 1.1.6.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ байгуулах, эрлийн гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, дүгнэх, санал дүгнэлт гаргах | Газрын тосны тухай хуульд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | “Баян эрхэт гүн” ХХК, “Монголын метан хийн харгуй” ХХК, “Юу Жи Эс” ХХК, “Хангад эксплорэйшн” ХХК, “Энержи ресурс” ХХК-уудаас ирүүлсэн нийт 9 эрлийн гэрээ байгуулах хүсэлтийн материалыг хүлээн авч, санал дүгнэлт гаргасан.<br>“Баян эрхэт гүн” ХХК-тай 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Говь-Алтай аймгийн нутагт нүүрсний давхаргын метан хийн эрлийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. “Хангад эксдлорэйшн” ХХК, “Энержи ресурс” ХХК-уудад эрлийн гэрээ байгуулах боломжтой талаар мэдэгдсэн. | |
| | 1.1.6.2. Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайд захиалга авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, хайгуулын талбайд болон эрлээс хайгуулд шилжиж байгаа талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах | Гэрээлэгчийг сонгон шалгаруулах журамд нийцсэн гэрээ байгуулсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Бүтэн жилд: Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын, ашиглалтын үйл ажиллагаа явуулах талаар 5 бүтээгдэхүүн хуваах гэрээ шинээр байгуулсан. 1 ажлын хэсэг томилогдон ажиллаж дүгнэлтээ Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн. | |
| 1.1.7. Монгол Улсын эрдэс баялгийн нөөцийг нэмэгдүүлэх геологийн эрэл, | 1.1.7.1. Хувийн хөрөнгөөр 2018, 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын хянагдаж баталгаажсан тайлан, төлөвлөгөөг Геологийн мэдээллийн төв архивд тушаах, хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлан | Холбогдох хууль журам, геологийн фондны журамд нийцүүлсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Нийт хайгуулын ажлын тайлан 467, хайгуулын ажлын төлөвлөгөө 550-ыг ҮГА-ы Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгсөн.<br>Ирүүлсэн хүсэлтийн хэмжээгээр холбогдох хууль журмын дагуу нийт 282 тодорхойлолт гаргаж өгсөн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| хайгуулын ажлыг төрөөс зөвшөөрсөн газар нутагт гүйцэтгэх, энэ чиглэлд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оруулна. Эрдэс баялгийн хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулж геологийн зураглал, эрэл, хайгуулын ажлыг нэмэгдүүлнэ. | ирүүлсэн болон тухайн жилийн зардлаа баталгаажуулсан тухай тодорхойлолт гаргах | | | |
| | 1.1.7.2. Хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тодотгол тайланг хянах, хяналтын хуудсаар дүгнэх, санд бүртгэх | Холбогдох хууль журамд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тодотгол тооцооны 102 тайлан ирүүлснийг аргачилсан зөвлөмж, холбогдох хууль, дүрэм журамд нийцүүлэн хянаж, холбогдох засвар өөрчлөлтийг хийлгэн шаардлага хангасан тайланг ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон байна.<br>Үүнийг ашигт малтмалын төрлөөр ангилбал:<br>• Үнэт, өнгөт металл – 44;<br>• Металл бус ашигт малтмал – 33;<br>• Цацраг идэвхт металл, газрын ховор элемент, хар, ховор металл – 14;<br>• Нүүрс - 11 тайланг тус тус хянаж ЭБМЗ-ийн хурлаар хэлэцүүлэхээр бэлтгэж ажилласан байна.<br>Ирүүлсэн тайлангийн мэдээллээр дээрх ашигт малтмалын төрлөөр мэдээллийн сан үүсгэсэн.<br>Бүтэн жилд нийт 102 тайланг хянаж заавар шаардлагад нийцүүлэн хүлээн авсан холбогдох мэдээллээр мэдээллийн сан үүсгэсэн байна. | |
| | 1.1.7.3. Төрөөс тогтоосон талбайд зарласан сонгон шалгаруулалтын талбайн ерөнхий мэдээлэл, геологи, ашигт малтмалын мэдээллийг бэлтгэх | Бүтэн жилд: 100% | Төрөөс тогтоон хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарласан нийт 64 талбайн геологийн тогтоц, ашигт малтмалын талаарх ерөнхий мэдээллийг бэлтгэв. Энэ ажлын хүрээнд Эрдэс баялаг, мэдээлэл технологийн төвийн(тухайн үеийн нэр) архивт хадгалагдаж буй 1:200 000, 1:50 000 ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлын тайлан, сэдэвчилсэн судалгааны тайлан зэрэг нийт 150 орчим судалгааны материалтай танилцан, холбогдох мэдээллийг зохих форматын дагуу багцлан бэлтгэсэн. | |
| | 1.1.7.4. Улсын төсвийн хөрөнгөөр хийх геологийн төрөл бүрийн судалгааны ажлын үр дүнгийн тайлан, заавар, ангилал, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөөц бүхий хайгуулын ажлын үр дүнгийн тайланд шинжээч томилуулахад бэлтгэх, ирүүлсэн тайлангийн бүрдлийг хянаж бүртгэх, хяналтын хуудас олгох | Хууль, журамд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын 2 тайланд, Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн 159 тайланд шинжээч томилуулах хүсэлт ирсний дагуу шийдвэрийн төсөл бичиж, шийдвэр гаргуулан аж ахуй нэгж, байгууллагад хүргүүлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | Дээрх шинжээч томилсон шийдвэрүүдийг бүртгэн статистик тоо баримт гарган дүрмийн хэрэгжилтийг ханган ажилласан.<br>Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын 40 тайланд, Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн 148 тайланд шинжээчийн гаргасан дүгнэлт, дүгнэлтийн хариу зэрэг бүрдлийг шалгаж хяналтын хуудас олгон бүртгэл хөтөлсөн. | |
| | 1.1.7.5. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн геологийн төрөл бүрийн судалгааны ажлын төсөл, төсвийн тодотгол, үр дүнгийн тайлан, хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангана. | Холбогдох дүрэм журмын дагуу шаардлага хангуулсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын тайлан, төсвийн тодотгол хэлэлцэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 5 хуралдаан зохион байгуулагдаж, нийт 4 тайлан, 36 төсвийн тодотгол хэлэлцсэн.<br>Хувийн хөрөнгийн тайлан хэлэлцэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 10 хуралдаан зохион байгуулагдаж, нийт 96 тайлан (95 нөөцийн тайлан, 1 стратегийн ордын нөөц) хэлэлцсэн байна. | |
| | 1.1.7.6. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хүлээн авахаар шийдвэрлэсэн хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тодотгол тайлангийн нөөцийг ашигт малтмалын төрлөөр бүртгэх, санг баяжуулах, нөөцтэй холбоотой мэдээ, мэдээлэл бэлтгэж өгнө. | Хуульд заасан хугацаанд бодит үнэн мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 12 мэдээ /100%/ | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, хурлын тэмдэглэлд үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын нөөц хүлээн авах 115 тушаал гарсан.<br>ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэн хүлээн авахаар шийдвэрлэсэн хайгуулын ажлын үр дүнгийн болон нөөцийн тодотгол тайлангийн нөөцийг ашигт малтмалын төрлөөр бүртгэн санг баяжуулах ажлыг хийсэн. Голлох ашигт малтмалын төрөл тус бүрээр тоймлон харуулбал:<br>1. Алтны үндсэн орд -11<br>2. Алтны шороон орд – 20<br>3. Жонш – 18<br>4. Төмөр – 3<br>5. Нүүрс – 8<br>6. Элс хайрга – 5<br>7. Шавар – 3<br>8. Элс – 6<br>9. Гянтболд – 1<br>10. Барилгын чулуу – 15 ордууд тус тус улсын нөөцөд бүртгэгдээд байна.<br>Нөөцтэй холбоотой мэдээ, мэдээллийг дээд шатны байгууллага болон удирдлагуудаас иргүүлэхийг даалгасан тохиолдолд тухай бүр, ХШҮСХ-т графикийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | дагуу сар бүр буюу 12 удаа статистик мэдээнд бэлтгэн гаргаж өгсөн. | |
| 1.1.8. Улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа бүх шатны геологийн судалгаа, олборлолт, боловсруулалтын ажлын талаарх хуулиар хориглоогүй мэдээллийг нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ. | 1.1.8.1. Улсын болон хувийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж байгаа бүх шатны геологийн судалгааны ажлын статистик болон Монгол орны ашигт малтмалын нөөцийн талаарх ерөнхий мэдээллийг гаргаж олон нийтэд байгууллагын сайт болон хэвлэлээр мэдээлэх | Үнэн бодит мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 12 | Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн, дүгнэлт, нөөц хүлээн авах тушаал нь гарсан 115 тайлангийн нөөцийг ашигт малтмалын төрлөөр бүртгэн сар бүрийн нөөцийн мэдээ, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцсэн болон хүлээн авсан тайлангийн мэдээг бэлтгэж, Хяналт шинжилгээ, үнэлгээ, статистикийн хэлтэст илгээсэн. | |
| 1.1.9. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ. | 1.1.9.1. Эрэл, хайгуулын үйл ажиллагааны үед байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө, төсвийг батлах, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг судалж, санал дүгнэлт гаргах, батлуулах, биелэлтийг хангуулах, хяналт тавих, санал дүгнэлт гаргах, орон нутаг, холбогдох төрийн байгууллагатай хамтарч ажиллах | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, холбогдох стандартын дагуу байгаль орчны ажлууд хийгдсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | 1 талбайд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулж, хэрэгжүүлсэн. 2 талбайд орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдсэн. 8 талбайн хайгуулын үйл ажиллагаа Ковид-19 тахлын улмаас зогссон. 6 цооногийн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээн авсан. 2 талбайд ажиллаж байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлын гүйцэтгэлд дүгнэлт гаргасан. | |
| 1.1.10. Цацраг идэвхит ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг төлөвлөнө. | 1.1.10.1. Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг шинэ талбайд эхлүүлэх бэлтгэл ажлыг хангахад Цөмийн энергийн комиссын ажлын албатай хамтран ажиллах | Холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн эрэл, хайгуулын ажлын үр дүнг нэгтгэж, хэтийн төлвийн үнэлгээ өгөх “Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний хэтийн төлөвийн судалгаа” төслийг Улсын төсвийн хөрөнгөөр 2013-2014 онд гүйцэтгэсэн нь өнөөдрийн байдлаар суурь мэдээлэл болж байна.<br>Цацраг идэвхт ашигт малтмалын 11 ордын мэдээллийн санг бүрдүүлсэн. Газрын ховор элемент хөтөлбөрийн төслийг боловсруулах ажлын хэсэг/УУХҮЯ-ны Геологийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн н.Оргил/-д Монгол орны газрын ховор элементийн ордууд, тэдгээрийн нөөцийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | нарийвчилсан мэдээллийг бэлтгэн 2019 оны 3 дугаар сарын 25-нд өгсөн.<br>Газрын ховор элементийн геологийн судалгаа, хайгуулын ажлыг нэмэгдүүлэх, цаашдын чиг хандлагыг тодорхойлох, судалгааны түвшинг дээшлүүлсний үндсэн дээр шинээр орд газруудыг тогтоож, улсын эрдэс баялгийн санг арвижуулах, бэлтгэгдсэн орд газруудыг олборлох, хүдрийг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар эдийн засгийн эргэлтэд шинээр оруулах хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, эдийн засгийн үр ашгийг тооцох үүрэг бүхий төслийн нэгжийг ЗГ-ын 2019 оны 176 дугаар тогтоолоор байгуулсан байна. | |
| 1.2.1. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна. | 1.2.1.1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын мэдээллийг шинэчлэх, ажлын хэсэгт орж ажиллах, холбогдох байгууллага, ажлын хэсгийг мэдээллээр хангах | Стратегийн ордуудын үнэн, бодитой мэдээллийг нэгтгэн холбогдох байгууллагуудыг үнэн, бодитой мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Стратегийн ач холбогдол бүхий ордын талбайн хил зааг тогтоох шаардлагатай 7 стратегийн ордын мэдээллийг нэгтгэж урьдчилсан байдлаар талбайн хил зааг тогтоон холбогдох яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх шатанд 2 удаа мэдээллээр хангаж ажилласан.<br>Стратегийн ордын мэдээллийн санг 2 удаа шинэчлэн баяжуулсан. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг 2 удаа мэдээллээр хангаж ажиллав.<br>Стратегийн ач холбогдол бүхий Зөөвч овоо, Дулаан уулын ураны ордыг эзэмшигчтэй Монгол Улсын Засгийн газрын хийсэн гэрээний орчуулгын алдааг залруулахад мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгч, ордуудын мэдээллээр хангаж ажилласан.<br>Оюу толгой төслийн танилцуулга шинэчлэн цаашид авч хэрэгжүүлэх ажлын санал бэлтгэж газрын даргад танилцуулсан. “Оюу толгойн ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллав.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 174 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 23 дугаар тушаалаар байгуулагдсан дэд ажлын хэсгийг холбогдох мэдээллээр хангаж ажиллав. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | Уул уурхай, Хүнд үйлдвэрийн сайдад стратегийн 16 ордын мэдээллийг 2020 оны 5 дугаар сарын 14-ны өдөр хүргүүлэв. | |
| 1.2.2. Засгийн газрын 2017.05.24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллана. | 1.2.2.1. Бичил уурхайн мэдээллийг санд нэгтгэх, холбогдох талуудыг мэдээллээр хангах, дүгнэлт гарсан талбайн үйл ажиллагаатай танилцаж мониторинг хийх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, УУХҮЯ-нд хүргүүлэх | Засгийн газрын 2015 оны 151 дүгээр тогтоолоор баталсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам хэрэгжсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Бичил уурхайтай холбоотой мэдээллээр удирдлага болон холбогдох байгууллагыг 7 удаа хангаж ажилласан. | |
| 1.2.3. Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулна. | 1.2.3.1. Нэгдсэн зохион байгуулалтад оруулах талаар хийгдсэн ажлын тайланг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэх | Цаг хугацаанд нь үнэн, бодитой тайлан бэлтгэж хүргүүлсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | 2015-2019 оны томилолтын тайлан, бичил уурхайн мэдээлэл, 2020 оны 2 аймгийн мэдээллээр хууль бусаар ашигт малтмал олборлогчдын мэдээллийн санг баяжуулсан.<br>Хууль бусаар ашигт малтмал олборлолтын мэдээ, тэдгээрийг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлын тайланг Уул уурхай, Хүнд үйлдвэрийн яаманд 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.2.4. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1.2.4.1. Алт-2 хөтөлбөрийг хэрэгжүүлэх, биелэлтийг гаргаж УУХҮЯ-нд хүргүүлэх, холбогдох байгууллагыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах | Алт-2 хөтөлбөрийн арга хэмжээ хэрэгжсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Алт 2 хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой мэдээллээр холбогдох байгууллыг 6 удаа хангаж ажилласан.<br>Алт-2 хөтөлбөрийн хүрээнд олгогдож буй зээлийн хүрээнд 12 аж ахуй нэгжид 200 орчим тэрбум.төг олгогдож, 2020 оны 11 дүгээр сарын байдлаар Монголбанкинд тушаасан алтны хэмжээ 21 тн хүрээд байна.<br>Монгол банк болон Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс, Баянхонгор аймаг дахь Монголбанкны салбарт уул уурхай болон бичил уурхайгаас тушаасан алтны мэдээг улирал бүр авч, мэдээллийн санд нэгтгэсэн. | |
| 1.2.5. Экспортын нэг цонхны бодлого хэрэгжүүлж, гааль, татвар, мэргэжлийн хяналт зэрэг төрийн үйлчилгээг цахим | 1.2.5.1. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг цахимаар хүлээн авах И-репорт цахим программд үнэлгээ хийх, цаашид хөгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, сайжруулалтын ажлыг хийх | Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах | ● И-репорт цахим программ ашигладаг аж ахуйн нэгжүүдээс судалгаа авав. Цаг тухайд нь программд хэрэглэгчийн мэдээлэл, тусгай зөвшөөрлийн мэдээллийг шинэчлэв.<br>● Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг цахимаар хүлээн авах И- | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| хэлбэрээр, эсхүл нэг цэгт үзүүлж, чирэгдлийг багасгана. | | заавар хэрэгжсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | репорт цахим программд үнэлгээ хийх ажлыг ажлын даалгаврын дагуу “Тайдер” ХХК нь хийж, тайланг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын А/12 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг хүлээж авав.<br>● И-репорт цахим программыг цаашид хөгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж “Ашигт малтмал, газрын тосны газрын цахим тайлангийн системийг тохируулах, өргөтгөх ажил үйлчилгээг тодорхойлох” ажлын даалгаврыг эцэслэж Монгол Улсын эрдэс баялгийн салбар дахь институцийн болон боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх-II төсөлд 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 1/2248 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>● Ковид-19 Коронавирус цар тахлын улмаас ХБНГУ-ын Геологийн шинжлэх ухаан, байгалийн нөөцийн хүрээлэнгийн үйл ажиллагаа зогсонги байдалтай болсон тул 2-р шатны хөгжүүлэлтийн санхүүжилтийн асуудал удааширч шийдэгдсэн бөгөөд 2020 оны 8 дугаар сарын 3-ны өдөр Тайдар ХХК-тай 212-10106775 тоот гэрээг байгуулснаар программын шинэчлэл, өргөтгөлийн ажил эхэлсэн. 2021 оны 6 дугаар сард гэрээт ажил дуусч, сайжруулалтын ажлыг бүрэн хүлээлгэж өгнө. | |
| 1.2.6. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, олон улсын тэргүүн туршлага, стандартыг нэвтрүүлэх, ногоон хөгжлийг дэмжин ажиллана. | 1.2.6.1. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар холбогдох хуулийг хэрэгжүүлэх, сөрөг нөлөөлөл багатай дэвшилтэт техник, технологи, олон улсын тэргүүн туршлага, стандартыг нэвтрүүлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангаж ажиллах | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, холбогдох стандартын дагуу байгаль орчны ажлууд хийгдсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайн 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүргүүлсэн бөгөөд 2020 оны 5 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан. Тосон-Уул XIX талбай 2019 онд өрөмдсөн 10 цооногийн зумпнээс дээж авч лабораторит шинжлүүлсэн. 1997 оны БХГ-т талбай 2 цооногт техникийн нөхөн сэргээлт, 10 га талбайд 1500 суулгац, 1 цооногийн талбайд мод суулгах туршилтын ажил, Байгаль орчны аудит, аудит мониторинг зэрэг ажилд хяналт тавьж ажилласан. | |
| 1.3.1. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 1.3.1.1. Ашиглалтад бэлтгэгдсэн ордуудын суурь судалгаа, бүсчилсэн танилцуулгыг шинэчлэн боловсруулж, бодлогын баримт бичиг боловсруулахад, шаардлагатай мэдээллээр ханган ажиллах | Эх үүсвэр нь тодорхой, үнэн зөв мэдээллээр хангасан эсэх | 2020 оны жилийн эцсийн байдлаар бүсчилсэн танилцуулгыг 8 удаа шинэчилж, стратегийн ордуудын мэдээллийг 1 удаа шинэчлэн боловсруулж мэдээллээр хангасан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | Бүтэн жилд: Шаардлагатай мэдээллээр хангасан байна. | | |
| | 1.3.1.2. Хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа нүүрс олборлох, ашиглах төслүүдийн техник-эдийн засгийн үндэслэлтэй холбогдох заавар журмын дагуу танилцаж, шаардлагад нийцүүлэн засварыг хийлгэх, танилцах хуудсаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх | Холбогдох заавар журмын дагуу танилцаж, шаардлагад нийцүүлэн засварыг хийлгэсэн эсэх<br>Бүтэн жилд: Шаардлагатай мэдээллээр хангасан байна. | 2020 оны жилийн эцсийн байдлаар 25 техник, эдийн засгийн үндэслэлтэй танилцаж, 22 техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээж авах Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаал боловсруулан батлуулж, 16 техник, эдийн засгийн үндэслэлд шинжээч томилуулах хүсэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн нарийн бичигт тухай бүр хүргүүлсэн. | |
| 1.3.2. Нүүрс баяжуулах, кокс, химийн үйлдвэр байгуулах, нүүрсний ордод түшиглэсэн цахилгаан станц барих, хүрэн нүүрснээс утаагүй, шингэн түлш, хий, шатдаг занараас шингэн түлш гарган авах зэрэг төслийг дэмжинэ. | 1.3.2.1. Хэрэгжихээр төлөвлөгдөж байгаа нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах төслүүдийн техник-эдийн засгийн үндэслэлтэй холбогдох заавар журмын дагуу танилцаж, шаардлагад нийцүүлэн засварыг хийлгэх, танилцах хуудсаар Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх | Холбогдох заавар журмын дагуу танилцаж, шаардлагад нийцүүлэн засварыг хийлгэсэн эсэх<br>Бүтэн жилд: Шаардлагад нийцүүлэн засварыг хийлгэж ажилласан байна. | 2020 оны жилийн эцсийн байдлаар нүүрс баяжуулах үйлдвэрийн 1 техник, эдийн засгийн үндэслэлтэй танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлсэн. Үүнд:<br>Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших Алагтогоогийн нүүрсний ордын Хойд Элдэв, Хойд Алагтогоогийн хэсгийн нүүрсийг нойтон аргаар баяжуулах үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэл. | |
| 1.4.1. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг тогтвортой хангах, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 1.4.1.1. Монгол Улсад газрын тосны бүтээгдэхүүний хангамжийг тогтвортой байлгах зорилтын хүрээнд гадаадын экспортлогч компаниудтай харилцаа холбоо тогтоох, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг судлах, авах арга хэмжээний талаар санал боловсруулах, удирдлагад танилцуулах, мэдээллээр хангах | Холбогдох хуульд нийцүүлсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | • ОХУ-д зохион байгуулсан уулзалтаар Монгол Улсад экспортод гаргах бүтээгдэхүүний тоо хэмжээг 2023 он дуустал бууруулахгүй байхаар шийдвэрлэсэн.<br>• БНХАУ-тай хиллэж буй зарим боомтуудын үйл ажиллагааг эхлүүлэхэд үүсээд буй бодит байдлын талаар 1 удаа хэлэлцүүлсэн.<br>• “Роснефть-Монголия” ХХК-д шатахууны нийлүүлэлтийг хэвийн хэмжээнд байлгах хүсэлтийг 2 удаа хүргүүлсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 1.4.2. Газрын тосны бүтээгдэхүүний техник, технологийн аюулгүй ажиллагааг хангана. | 1.4.2.1. Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлтийн аюулгүй ажиллагаатай холбогдсон стандарт, дүрэм, журмыг боловсронгуй болгох, санал өгөх, сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулан ажиллах | Хуульд нийцүүлэн ажилласан эсэх<br>Бүтэн жилд: 100% | “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-ийн төсөлд санал боловсруулан байгууллагын ХЭЗХ-т хүргүүлэв.<br>“Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ыг шинэчлэн боловсруулав.<br>Газрын тосны бүтээгдэхүүний асуудал эрхэлсэн төрийн захиргааны бүрэн эрхийн ажлын хүрээнд газрын тосны бүтээгдэхүүн, шингэрүүлсэн шатдаг хийн төлөвлөлт болон хадгалалт, тээвэрлэлт, түгээлтийн техник, тоног төхөөрөмжийн технологийн угсралтын үеийн стандартын төслийг шинээр боловсруулан УУХҮЯ-нд хүргүүлж, тус яамнаас 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 03/808 тоот албан бичгээр СХЗГ-т батлуулахаар хүргүүлэв.<br>Дизелийн түлш. Техникийн шаардлага болон завсрын бүтээгдэхүүний 6 стандарт шинээр боловсруулан Стандарт хэмжил зүйн газрын даргын 2020 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн С/35 тоот тушаалаар батлагдсан.<br>Газрын тосны бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэлт хийх журмын төсөлд санал боловсруулан Улаанбаатар төмөр замын тээвэр тээвэр зохион байгуулалтын албанд 2020 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 3/828 тоот албан бичгээр хүргүүлсэн. | |
| 1.5.1. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлнэ. | 1.5.1.1. Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайд газрын тосны олборлолтыг нэмэгдүүлэх зорилгоор 2020 онд хийгдэж буй цооногийн өрөмдлөг, перфораци, шингэн хагалбар, цооног үйлчилгээний ажлын гүйцэтгэлд газар дээр нь байнгын хяналт тавьж ажиллах, удирдлагыг тогтмол мэдээллээр хангах | Батлагдсан төлөвлөгөө, төсөвт хяналт тавьсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар Тосон-Уул XIX талбайд 4 цооногт перфораци, 3 цооногийн 5 үед шингэн хагалбар, 88 цооногт засвар үйлчилгээний ажил, Тамсаг XXI талбайд 4 цооногт перфораци, 3 цооногийн 5 үед шингэн хагалбар, 82 цооногт засвар үйлчилгээний ажил, 1997 оны БХГ-т талбайд 5 цооногт перфораци, 64 цооногт засвар үйлчилгээний ажил тус тус хийгдсэн. Хэлтсийн мэргэжилтнүүд албан томилолтоор ээлжлэн ажиллаж, цооногийн перфораци, шингэн хагалбар, цооног үйлчилгээний ажлын гүйцэтгэлд газар дээр нь хяналт тавьж, Баасан гараг бүр удирдлагыг мэдээллээр хانган ажилласан. | |
| | 1.5.1.2. Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайгаас 2019 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн | Батлагдсан төлөвлөгөө, төсөвт хяналт тавьсан эсэх | 2019 онд олборлосон шингэн, үүнээс ус, тос, хийн хэмжээ, экспортолсон тосны хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг гаргаж, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | хэмжээ, экспортолсон тосны хэмжээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд ашигласан усны хэмжээг гэрээлэгчидтэй тулган баталгаажуулна. | Бүтэн жилд: 100% | Тосон-Уул XIX талбайн тооцоог 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдөр, Тамсаг XXI талбайн тооцоог 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр, 1997 оны БХГ-т талбайн тооцоог 2020 оны 9 дүгээр сарын 6-ны өдөр тус тус гэрээлэгчидтэй тулган, баталгаажуулсан. | |
| | 1.5.1.3. Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны БХГ-т талбайгаас 2020 онд олборлож, экспортлох түүхий тосны ачилтын тоо хэмжээ, чанарын шинжилгээнд газар дээр нь хяналт тавьж ажиллах, тоо хэмжээг сар бүрээр гаргаж, улирал бүрээр гэрээлэгчидтэй тулган, баталгаажуулах | Батлагдсан төлөвлөгөө, төсөвт хяналт тавьсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Бүтэн жилд: Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт 6.6 сая баррель буюу 897 мянган тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2020 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн байдлаар 3,599,004 баррель буюу 490,048 тонн түүхий тос олборлож, 3,598,554 баррель буюу 490,651 тонн түүхий тос БНХАУ-д экспортлоод байна. Олборлолтын гүйцэтгэл 54.53 хувь, экспортын төлөвлөгөөний гүйцэтгэл 54.52 хувьтай байна.<br>Газрын тосны олборлолт, экспортын мэдээг сар бүрээр гаргаж, улирал бүр нэгтгэн гэрээлэгч компанийн холбогдох мэргэжилтнүүдтэй тулган баталгаажуулж ажилласан. | |
| 1.7.1. Хүнд үйлдвэрийн хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | 1.7.1.1. Хүнд үйлдвэрийг дэмжих тухай хуулийн төсөл, холбогдох дүрэм, журмыг боловсруулах ажилд санал өгч ажиллах | хуулийн төсөлд үнэн зөв, шаардлага хангахуйц санал боловсруулж ажилласан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Хуулийн төсөл, холбогдох дүрэм, журмыг боловсруулах 5 төсөлд холбогдох саналыг боловсруулж хүргүүлсэн. | |
| 1.7.2. Өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, зэсийн баяжмал боловсруулах үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ. | 1.7.2.1. “Зэсийн баяжмал хайлуулах цэвэршүүлэх үйлдвэрийн төсөл”-ийн хүрээнд гарсан Засгийн газрын тогтоол, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан ажлын хэсгийг мэдээллээр хангах, батлагдсан дүрэм, журам, зааврuудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн, төслийн нэгжтэй хамтран ажиллах | Үнэн зөв шаардлага хангахуйц мэдээ, мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төслийн техник, эдийн засгийн үндэслэлд нэмэлт тодотгол оруулахаар төмөр зам болон дэд бүтцийн холбогдох судалгааг хийж, саналаа өгч ажилласан. | |
| | 1.7.2.2. Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр байгуулах ажлын хэсэгт орж ажиллан холбогдох санал, дүгнэлтийг хүргүүлэх | Үнэн зөв шаардлага хангахуйц мэдээ, мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийн БОННҮ-ний тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны салбар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тусгай зөвшөөрөл олгосонтой холбоотой хайгуулын ажлын төлөвлөгөө батлуулан ажиллах санал хүргүүлсэн. Хайгуулын ажлын төлөвлөгөөний дагуу толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-д 2020-2021онд хайгуулын ажилд зарцуулах зардлын төсөв | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | батлуулахаар ажиллаж байна. Алт цэвэршүүлэх төслийн ажлын хүрээнд гадаад орнуудад үйл ажиллагаа явуулж байгаа ижил төрлийн цэвэршүүлэх үйлдвэрийн судалгаа хийж гүйцэтгэсэн. | |
| 1.7.3. Хар төмөрлөгийн үйлдвэрлэлийг дагалдах үйлдвэрүүдийн хамт хөгжүүлнэ. | 1.7.3.1. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах ажлын хэсэгт орж, Засгийн газрын тогтоол, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэхээр байгуулагдсан ажлын хэсгийг мэдээллээр хангах, батлагдсан дүрэм, журам, заавруудын хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэн санал дүгнэлтээ хүргүүлэх | Үнэн зөв мэдээ, мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Төмрийн хүдрийг боловсруулах болон гангийн үйлдвэрүүдийн хүчин чадлыг сайжруулах, техник технологийн түвшинг сайжруулах ажлын хэсэгт орж, газар дээр нь ажиллаж санал дүгнэлтээ хүргүүлэн ажилласан. “Эрдэнэс стийл” ХХК-ийн Говьсүмбэр аймгийн Баянтал сумын нутаг, Чойрын Эдийн засгийн чөлөөт бүсэд хэрэгжүүлж байгаа кокс төмөрлөгийн цогцолбор үйлдвэрийг барьж байгуулахад зохион байгуулалт, зохицуулалтыг дэмжих ажлын хэсэгт орж санал дүгнэлтээ хүргүүлсэн. | |
| 1.7.4. Нүүрс гүн боловсруулах болон химийн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 1.7.4.1. Нүүрс гүн боловсруулах болон химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд түлхэц болох дэд бүтэц, зах зээлийн холбогдох судалгаа хийх , холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах | Үнэн зөв мэдээ, мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Гашуунсухайт, Бичигтийн боомтоор 2018, 2019 онд экспортолсон нүүрсний экспортын судалгааг 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 14/2371 тоот албан бичгээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн хэлтэст хүргүүлсэн.<br>Нүүрсний гадаад зах зээлийн импортын хэрэгцээ, нүүрсний боловсруулалтын бүтээгдэхүүний дотоодын эрэлтийг судалж, мэдээлэл бэлтгэж, танилцуулсан.<br>Кокс химийн үйлдвэрийн /Таван толгой транс компаний коксын үйлдвэр г.м./ хүчин чадлыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх санал боловсруулж, танилцуулсан.<br>Үйл ажиллагаа нь зогсонги байдалд орсон Төв аймагт байрлах Хөхэрт натрийн үйлдвэрийн нөхцөл байдалтай танилцах уулзалтыг УУХҮЯ-ны Хүнд үйлдвэрийн газарт зохион байгуулсан. Одоогоор Шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагаа уг үйлдвэр дээр явагдаж байгаа ба Ковид 19-ийн улмаас ажиллагаа зогссон байдалтай байна. | |
| 1.7.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хэрэгжилтийг хангаи ажиллана. | 1.7.5.1. Газрын тос боловсруулах үйлдвэрийн мэдээ тайлангаар удирдлагуудыг хангаи ажиллах | Үнэн зөв шаардлага хангахуйц мэдээ, тайлан гаргасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Газрын тосны 18 мэдээ тайлан боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн. | |
| 1.7.6. Метал хийц, тоног төхөөрөмж, машин | 1.7.6.1. Метал хийц, машин угсрах болон автомашины эд анги үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал ашиглалт, | Үнэн зөв шаардлага хангахуйц мэдээ, | Металл хийц, машин угсрах болон автомашины эд анги үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдийн хүчин чадал ашиглалт, машин угсрах болон автомашины эд | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг дэмжин ажиллана. | бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн судалгааг хийх, танилцуулах | мэдээллээр хангасан эсэх<br>Бүтэн жилд: 100% | ангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн судалгаа хийж УУХҮЯ-нд хүргүүлсэн. Металл хийц, машин угсрах болон автомашины эд анги үйлдвэрлэж буй аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажилласан. | |
| 1.8.1. Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4.3.2-р заалт “Евро-5” стандартад нийцсэн чанарын шаардлага хангасан шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах” заалтыг хэрэгжүүлэхэд газрын тосны бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийнэ. | 1.8.1.1. Газрын тосны бүтээгдэхүүнд чанарын шинжилгээ хийх, нийтийн тээврийн хэрэгсэл болон автомашины түлшинд агуулагдах нийт хүхрийн хэмжээг тодорхойлох шинжилгээ хийх | “Дизелийн түлш MNS 0216:2017”-д заасан ASTM D5453-09 аргын стандартад нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Дизель түлшний 85 ширхэг дээжид нийт 1190 ширхэг үзүүлэлтээр физик химийн шинж чанарын шинжилгээг стандарт арга аргачлалын дагуу хийж, үр дүнг боловсруулан сорилтын тайланг хэвлэн лабораторийн даргаар баталгаажуулж захиалагч байгууллагад тухай бүр хүргүүлж ажилласан. | |
| 1.8.2. Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан сайжруулсан түлшний физик химийн шинж чанар, үзүүлэлтүүдийг тодорхойлж, шинжилгээг хийнэ. | 1.8.2.1. Сайжруулсан шахмал түлшний дээжид физик химийн шинж чанарыг тодорхойлох шинжилгээг хийж, үр дүнг боловсруулан сорилтын тайланг гаргах | “Сайжруулсан хатуу түлш” Техникийн шаардлага. MNS 5679-2019 стандартад нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар болон үйлдвэрлэгч Таван толгой түлш ХХК-аас ирүүлсэн сайжруулсан хатуу түлшний нийт 251 дээжид MNS 5679:2019 стандарт шаардлагын дагуу 1255 үзүүлэлтээр шинжилгээг гүйцэтгэн тайлан нэгтгэл гарган захиалагч байгууллагад хүргүүлсэн. | |
| ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ | | | | |
| 2.1.1. Гэрээлэгчид 2020 онд гадаадаас авах ажиллах хүчний асуудлыг судалж Уул уурхай, | 2.1.1.1. “Петрочайна Дачин Тамсаг”, “Доншен газрын тос (Монгол)” ХХК-уудын 2020 онд гадаадаас авах ажиллах хүчний асуудлыг шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахад дэмжлэг үзүүлсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Засгийн газрын 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 164 дугаар тогтоолоор Тосон-Уул, Тамсагийн сав газарт ажиллах “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн нийт 664 гадаад мэргэжилтэнд, “Доншен Газрын Тос” ХХК-ийн нийт 117 гадаад мэргэжилтэнд 2020 онд | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлнэ. | | | Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсэн. | |
| 2.2.1. АМГТГ-ын үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ боловсруулан, статистик мэдээний эмхтгэл тайлан гаргаж, удирдлага болон хэрэглэгчдийг мэдээллээр хангаж, холбогдох газруудад хүргүүлнэ. | 2.2.1.1. Статистик мэдээг тогтоосон хугацаанд хэлтсүүдээс хүлээн авч нэгтгэн, эрдэс баялгийн статистик мэдээний эмхтгэлийг сар бүр боловсруулан гаргана. | Шаардлага хангахуйц үнэн зөв мэдээлэлтэй эсэх Эхний хагас жилд: 50% | Үнэн зөв мэдээлэлтэй газрын хэмжээний статистик мэдээний эмхтгэлийг 12 удаа нэгтгэн боловсруулсан. | |
| | 2.2.1.2. Статистик мэдээний эмхтгэлийг англи хэлээр хөрвүүлэн, монгол, англи хэлээр агентлагийн вэб хуудсанд байршуулан байгууллагын удирдлага, холбогдох төрийн байгууллагуудад тархаана. | Шаардлага хангахуйц үнэн зөв мэдээлэлтэй эсэх Эхний хагас жилд: 6 удаа | Монгол хэл дээрх эмхтгэлийг англи хэл рүү хөрвүүлэн, агентлагийн вэб хуудсанд байршуулахад бэлтгэн, монгол англи хэл дээрх файлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн холбогдох мэргэжилтэнд нийт 12 удаа хүргүүлсэн. | |
| 2.4.1. Автобензин болон дизель түлш, нүүрс, хатуу түлш болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас бохирдсон газрын хөрс, усны дээжүүдэд техникийн болон бусад шинжилгээнүүдийг захиалгаар хийж гүйцэтгэн төсөвт орлого төвлөрүүлнэ. | 2.4.1.1. Гаалийн Ерөнхий газрын харьяа Гаалийн Төв лаборатори болон бусад захиалагч нараас ирүүлсэн автобензин болон дизель түлшний дээжүүдэд техникийн болон бусад шинжилгээнүүдийг хийж төсвийн даалгаврыг гүйцэтгэх | Хууль, дүрэм, журам, стандартыг мөрдсөн эсэх Бүтэн жилд: 100% | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын А/28 дугаар тушаалын дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус лабораторийн газрын тосны асуудал хариуцсан шинжээч Б.Өлзий, Ж.Бадамсүрэн нар ажилласан. Ажлын хэсгээс гарсан шийдвэрийн дагуу хот доторх томилолт гүйцэтгэх төлөвлөгөөг боловсруулж Улаанбаатар хотын 6 дүүргийн 70 шатахуун түгээх станцуудаар борлуулагдаж буй шатахууны төрөл бүрээс дээж авч, шаардлагатай гэж үзсэн 98 ширхэг дээжүүдийг шинжилгээнд хамруулж ажилласан. Үүнээс дизелийн түлшний 35, ширхэг автобензиний 63 ширхэг дээжид нийт 15.750.000 төгрөгийн өртөгтэй шинжилгээг хийсэн.<br>Шударга Өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын даргын 2020 оны 4 сарын 20-ны өдрийн 01/25 дугаар тоот ажлын хэсгийн удирдамжийн дагуу Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Стандарт хэмжил зүйн газартай хамтарсан шатахууны чанарт гэнэтийн шалгалт хийх ажлын хэсэгт ажилласан. Гэнэтийн хяналт шалгалтаар Улаанбаатар хотод борлуулагдаж буй шатахуун түгээх станцуудаас нийт 53 ширхэг дээж авч бүрэн шинжилгээг хийсэн ба үр дүнг Нийслэлийн мэргэжлийн хяналтын газарт хүргүүлж ажилласан. Нийт 9.010.000 төгрөгийн өртөгтэй шинжилгээг хийсэн. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | Нийт дизель түлшний 210 ширхэг, автобензины 106 ширхэг дээжид нийт 4318 ширхэг үзүүлэлтээр физик химийн шинж чанарын шинжилгээг стандарт арга аргачлалын дагуу хийж, үр дүнг боловсруулан сорилтын тайланг хэвлэн лабораторийн даргаар баталгаажуулж захиалагч байгууллагад тухай бүр хүргүүлж ажилласан. | |
| | 2.4.1.2. Гаалийн Ерөнхий газрын харъяа Гаалийн Төв лаборатори болон бусад захиалагч нараас ирүүлсэн нүүрс, хатуу түлш болон уул уурхайн үйл ажиллагааны улмаас бохирдсон газрын хөрс, усны дээжүүдэд техникийн болон бусад шинжилгээнүүдийг хийж төсвийн даалгаврыг гүйцэтгэх | Стандартыг мөрдсөн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Гаалийн Төв лабораториос ирүүлсэн нүүрс, хатуу түлшний 827 дээж 5789 үзүүлэлт, иргэд аж ахуй нэгжийн 522 дээжид 2610 үзүүлэлтээр техникийн болон бусад шинжилгээнүүдийг хийж гүйцэтгэн захиалагч байгууллагуудад тухай бүр сорилтын тайланг хүргүүлэн ажилласан, төсөвт 195.555.102.00 төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан. | |
| ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ<br>/ ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРЭГ / | | | | |
| 3.1.2.1. Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийг хангана. | 3.1.2.1.1. Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.9 дэх заалтын дагуу хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах талаар судалгаа хийж, үнэлэлт өгч, санал, дүгнэлт гаргах, хөрөнгө оруулалтын цахим хуудсыг шинэчлэх | Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.9 дэх заалтанд дурдсан хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах арга хэмжээ хэрэгжсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчныг сайжруулах судалгааны асуулгыг боловсруулж, тусгай зөвшөөрөл эз,эмшигчид болон уул уурхайн салбарын үйл ажиллагаанд оролцдог холбогдох байгууллагуудад хүргүүлэн, асуулгын хариултыг хүлээн авч, нэгтгэн боловсруулж, шинжилгээ хийн үнэлэлт өгч, дүгнэлт гарган Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.<br>Эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын мэдээлэл цуглуулж, цахим хуудас шинэчлэх зардлыг төсөвт суулгаж, цуглуулсан мэдээлэлд боловсруулалт хийн тайлбар бичиж, цахим хуудаст оруулахад бэлэн болгож цахим хуудсыг шинэчлэх ажлыг зохион байгуулсан. | |
| | 3.1.2.1.2. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг аж ахуйн нэгжүүдээс хүлээн авч танилцах, техник, эдийн засгийн үндэслэлийн үндсэн үзүүлэлтүүд, уул уурхайн үйлдвэрлэл, экспорт, эдийн засаг, хөрөнгө оруулалт, хүний нөөц, техник, технологи, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны нөхөн сэргээлт баяжуулах үйлдвэрийн мэдээллийг санд нэгтгэх, | Ашигт малтмалын тухай хуулийн 48.4, 48.6 дахь хэсэг хэрэгжсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | ● Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хүлээн авсан нийт 85 Техник, эдийн засгийн үндэслэлээс мэдээллийг авч, мэдээллийн санг баяжуулсан.<br>● 2019 оны баталгаажсан 187 тайлантай танилцаж мэдээллийг авч, санг хөтлөв.<br>● 2020 оны баталгаажсан 287 төлөвлөгөөтэй танилцаж мэдээллийг авч, санг хөтлөв<br>● 2021 оны ирүүлсэн 315 төлөвлөгөөтэй танилцаж мэдээллийг авч, санг хөтлөв. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | санал, дүгнэлт гаргах, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах | | | |
| **3.1.3.1.** Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэх, хугацааг нь сунгах, барьцаалах, тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг буцааж хүлээлгэн өгөх өргөдлийг хүлээн авч шийдвэрлэнэ. | 3.1.3.1.1. Аж ахуйн нэгж, байгууллагаас ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч бүртгэх, хянан шийдвэрлэх, тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Тайлангийн хугацаанд Ашигт малтмалын тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн 78 өргөдлийн материалын бүрдэлд анхан шатны шүүлт хийн хүлээн авч Уул уурхайн компьютержсэн кадастрын системд бүртгэсэн. Шинээр ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох 53, татгалзсан 4 шийдвэр, мэдэгдлийн төсөл боловсруулан, батлуулж хүргүүлэв. | |
| | 3.1.3.1.2. Тусгай зөвшөөрөл барьцаалах, талбайг буцаан өгөх, хугацааг сунгах, нөхөн олгох, шилжүүлэх өргөдлийг хүлээн авч бүртгэх, хянан шийдвэрлэх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | • Ашигт малтмалын 47 тусгай зөвшөөрлийг банк болон банк бус санхүүгийн байгууллагад барьцаалсныг хянан шийдвэрлэж, Уул уурхайн кадастрын компьютержсэн системд бүртгэсэн. Тусгай зөвшөөрлийг барьцаалсныг бүртгэх тухай шийдвэрийн дагуу гарсан мэдэгдлийг барьцаалагчид тухай бүр хүргүүлж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт сар бүр мэдэгдэн сонинд нийтлүүлсэн.<br>• Банк болон банк бус санхүүгийн байгууллагын барьцаанаас чөлөөлсөн 22 тусгай зөвшөөрлийн бүртгэлийг хянан шийдвэрлэж Уул уурхайн кадастрын компьютержсэн системд бүртгэсэн. Тайлангийн хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагаас ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайг бүхэлд нь болон хэсэгчлэн буцаах нийт 60 өргөдөл, бүхэлд нь болон хэсэгчлэн буцаахаас 4 өргөдлийг татгалзаж шийдвэрлэсэн.<br>• Ашигт малтмалын хайгуулын 64 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, хайгуулын 8 тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан шийдвэр гарсан.<br>• Ашигт малтмалын 14 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтыг нөхөн олгосон, 5 тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтыг нөхөн олгохоос татгалзсан.<br>• Ашигт малтмалын 72 тусгай зөвшөөрлийг бүхэлд нь, 11 тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой хэсгийг шилжүүлснийг хянан шийдвэрлэж Уул уурхайн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| --- | --- | --- | --- | --- |
| | | | компьютержсэн кадастрын системд бүртгэсэн. Шийдвэрийн дагуу гарсан мэдэгдлийг тухай бүр эзэмшигчид хүргүүлж, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газарт сар бүр мэдэгдэн сонинд нийтлүүлсэн. | |
| | 3.1.3.1.3. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь хэсэгт зааснаар бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлтийн төсөл боловсруулах, хүргүүлэх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Тайлангийн хугацаанд Монгол улсын Засгийн газраас баталсан 2019 оны 355, 2020 оны 17 дугаар тогтоолууд болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 01/493 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийг үндэслэн бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талбайн дүгнэлт гараагүй болно. | |
| | 3.1.3.1.4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсч орон нутагт гаргасан өргөдлийн дагуу шүүлт хийж, холбогдох дүгнэлтийн төсөл боловсруулах, хүргүүлэх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | 2020 оны 4 улирлын байдлаар хяналтын шатанд орон нутгийн Засаг даргаас түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн 198 өргөдөл бүртгэлтэй байна. Үүнээс түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох боломжтой 50, олгох боломжгүй 44 өргөдөлд дүгнэлт гарган аймаг, нийслэл орон нутаг руу хүргүүлсэн. Зам, тээврийн хөгжлийн яамнаас ирүүлсэн түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах нийт 85 талбайг Уул уурхайн кадастрын компьютержсэн системд шүүж, холбогдох мэдээлэл болон албан тоотыг хүргүүлэв. | |
| 3.1.3.2. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зарлах, хайгуулын тусгай зөвшөөрөл олгох ажлыг зохион байгуулна. | 3.1.3.2.1. Сонгон шалгаруулалтаар тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбайг ялган бэлтгэж орон нутгийн Засаг даргын саналыг авч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд санал хүргүүлэх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой 1.3 сая талбайг нэмж ялган багцалж бэлтгэсэн. | |
| | 3.1.3.2.2. Сонгон шалгаруулалт зарлах талбайг багцалж, бэлтгэл ажлыг хангах, нийтэд зарлах, Сонгон шалгаруулалтын багц мэдээлэл тараах, саналыг хүлээн авч бүртгэх, тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулах, Сонгон шалгаруулалт зарлагдсан талбайг Кадастрын бүртгэлийн системд бүртгэх, санал ирүүлээгүй талбайг бүртгэлээс хасах | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Тайлангийн хугацаанд нийт сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл хангаж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал авч, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын тушаалын төсөл бэлтгэж, олон нийтэд зарлах ажлыг зохион байгуулсан.<br>2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар нийт 7 багцаар /СШ-41, СШ-42, СШ-43, СШ-44, СШ-45, СШ-46, СШ-47/ дугаартай 285,176.45 га бүхий 65 талбайд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас санал авч, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | тушаалын төсөл бэлтгэж, олон нийтэд зарлах ажлыг зохион байгуулж<br>2020 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн зарласан /СШ-41, СШ-42, СШ-43, СШ-44/ дугаартай сонгон шалгаруулалтаар 68,912.18 га бүхий 27 талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон.<br>Улсын онцгой комиссын 2020 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 11 дүгээр тогтоолыг үндэслэн Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/47 дугаар тушаалаар 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр зарласан 41 дугаартай сонгон шалгаруулалтын 9 талбайг хүчингүй болгосон.<br>2020 оны 8 дугаар сарын 14-нөөс эхлэн 7 удаагийн сонгон шалгаруулалтаар зарласан 65 талбайг Уул уурхайн компьютержсэн кадастрын системд бүртгэсэн. Санал ирээгүй 16 талбайг Уул уурхайн компьютержсэн кадастрын системийн бүртгэлээс хасч бүртгэсэн | |
| 3.1.3.3. Улсын төсөвт орлого төвлөрүүлнэ. | 3.1.3.3.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөрөөр 37 тэрбум төгрөг, кадастрын үйлчилгээний хөлсөөр 1 тэрбум төгрөг, сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох ажлын хүрээнд 11.25 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 49,25 тэрбум төгрөг | • Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын нийт 2096 тусгай зөвшөөрлийн эхний болон ээлжит жилийн төлбөрөөр 27,983,511,169.65 /хорин долоон тэрбум есөн зуун наян гурван сая таван зуун арван нэгэн мянга нэг зуун жаран есөн төгрөг жаран таван мөнгө/ Тусгай зөвшөөрлийн төлбөрийн алдангиар 238,844,469.67 /Хоёр зуун гучин найман сая найман зуун дөчин дөрвөн мянга дөрвөн зуун жаран есөн төгрөг жаран долоон мөнгө/-г Улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>• Ашигт малтмалын кадастрын үйлчилгээний хөлсөөр нийт 712,439,176.00 /долоон зуун арван хоёр сая дөрвөн зуун гучин есөн мянга нэг зуун далан зургаа/ төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн.<br>• Ашигт малтмалын сонгон шалгаруулалтын журмаар тусгай зөвшөөрөл олгох ажлын хүрээнд 3.9 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. | |
| 3.1.4.1. Монгол Улсын газрын тосны бүтээгдэхүүний | 3.1.4.1.1. 2020 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэх 22 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулах, | Холбогдох хууль, журамд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Засгийн газрын 409 дүгээр тогтоолын дагуу 2020 онд газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц бүрдүүлэн ажиллаж буй 22 аж ахуйн нэгжтэй | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| хэрэгцээг тогтвортой хангах, импортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | гэрээний хэрэгжилтэд хяналт тавин ажиллах | | байгуулсан гэрээний хэрэгжилтэд 3 удаа хяналт тавьсан. | |
| | 3.1.4.1.2. Газрын тосны бүтээгдэхүүний бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авах, сунгуулахаар техникийн дүгнэлт авахаар ирүүлсэн өргөдлийн дагуу агуулах, шатахуун түгээх станцад техникийн дүгнэлт гаргах, бүртгэлийн гэрчилгээ олгох | Холбогдох хууль, журамд нийцсэн эсэх Бүтэн жилд: 100% | Байгууллага /АМГТГ/-ын даргын 20 удаагийн тушаалаар 68 аж ахуйн нэгжийн 24 агуулах, 236 шатахуун түгээх станцад техникийн дүгнэлт гарган, бүртгэлийн гэрчилгээ олгож, шаардлага хангаагүй 4 аж ахуйн нэгжийн 1 агуулах, 52 шатахуун түгээх станцын материалыг буцааж, зөвлөмж өгч “Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам”-ын хэрэгжилтийг хангуулсан.<br>Хууль, журмын хэрэгжилтийг хангах болон 21 аймагт болон Улаанбаатар хотод газрын тосны бүтээгдэхүүний үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн агуулах, түгээх станцын баримт бичгийг online хэлбэрээр буюу цахим программаар хянаж хүлээн авах асуудлыг шийдвэрлэж ажиллав. | |
| 3.1.5.1. Газрын тос, улмажлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавина. | 3.1.5.1.1. Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2019 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэн дүгнэх, 2020 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, батлуулах | Төлөвлөгөө, тайлан батлагдсан эсэх Бүтэн жилд: 100% | Тосон-Уул XIX, Тамсаг XXI, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2019 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцэн дүгнэх ажлын явцад шинэ коронавирусын улмаас Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр, 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 64 дүгээр, 2020 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоолоор БНХАУ-ын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын бүх боомтоор БНХАУ-ын иргэд болон тус улсаас ирж байгаа гуравдагч орны иргэн, харьяалалгүй хүнийг 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 4 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд Монгол Улс руу нэвтрүүлэх хөдөлгөөнийг зогсоох тухай шийдвэр гарсан. Иймд БНХАУ-ын иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтрэх боломжгүй болсон тул баталгаажаагүй. Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2020 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2020 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр, 1997 оны БХГ-т талбайн 2020 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр тус тус батлуулсан. | |
| ГУРАВДУГААР ХЭСЭГ. ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ / ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРЭГ / | | | | |
| 3.2.1.1. Байгууллагын | | Мэдээллийг бодит гүйцэтгэлээр хуулийн | Шилэн дансны тухай хуульд заасны дагуу төсөв, санхүүтэй холбогдолтой 111 мэдээлэл болон 5 сая | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| нээлттэй ил тод байдлыг хангана. | 3.2.1.1.1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүтэй холбогдолтой төлөвлөгөө, тайлан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэх | хугацаанд байршуулсан эсэх Бүтэн жилд: Төлөвлөгөө, тайлан болон 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого болон зарлагын гүйлгээний мэдээллийг бодит гүйцэтгэлээр хуулийн хугацаанд байршуулсан байна. | төгрөгөөс дээш үнийн дүнтэй нийт 272.7 тэрбум төгрөгийн орлого, зарлагын гүйлгээний мэдээллийг тухай бүр шилэн дансанд байршуулсан. | |
| | 3.2.1.1.2. Агентлагийн веб хуудсыг шинэчлэн, шаардлагатай мэдээ, мэдээллийг оруулж ажиллах | Үнэн зөв, бодитой мэдээ, мэдээллийг нийтэлсэн эсэх Бүтэн жилд: 100% | Байгууллагын цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар 156 мэдээ мэдээлэл оруулсан. Үүнд: тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний мэдээ 5, аж ахуйн нэгжүүдийн анхааралд мэдээ 72, хэвлэлийн бага хурлын мэдээ 2, статикийн 12 сарын 18 мэдээ, тусгай зөвшөөрөл холбогдолтой 36 мэдээлэл оруулж олон нийтэд цахим хэлбэрээр түгээсэн. | |
| | 3.2.1.1.3. Салбарын үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв, үйл ажиллагааны үр дүнг хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах | Үнэн зөв, бодитой мэдээ, мэдээллийг бэлтгэн нийтлүүлсэн эсэх Бүтэн жилд: 100% | Агентлагийн болон салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 817 мэдээ, мэдээлэл ОНХМХ гарснаас сөрөг мэдээлэл 3, Телевиз, 26 мэдээллийн сайт, 6 өдөр тутмын сонин, 1 радиогоор дамжуулан хэвлэлийн 188 мэдээ бэлтгэн олон нийтэд мэдээлсэн. www.mrpam.gov.mn сайтад 2020 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн байдлаар Салбарын үйл ажиллагаатай холбоотой нийт 71 мэдээ оруулж, Монголын мэдээ, Үндэсний шуудан сонинд 66 зарыг нийтлүүлсэн. Цахим болон пэйж хуудасны хандалтаараа тэргүүлсэн хэвээр байна. | |
| 3.2.1.2. Гадаад орнуудаас ирүүлсэн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 3.2.1.2.1. Геологи, уул уурхай, газрын тосны салбарт хэрэгжиж байгаа болон хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн ажлыг нэгтгэн зохион байгуулж, бүтцийн холбогдох нэгжүүдтэй хамтран ажиллах | Хуулийн хүрээнд зохион байгуулж ажилласан эсэх Бүтэн жилд: 100% | АМГТГ-т гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй 3 төслийн явц хэвийн үргэлжилж байгаа бөгөөд 1 төслийг 2021 оноос шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн судалгааны ажил хийгдэж байна. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| 3.2.1.3. Авлигатай тэмцэх төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 3.2.1.3.1. Авлигатай тэмцэх төрийн бодлого, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, авлигын эсрэг 2020 оны төлөвлөгөөг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулах, Ашигт малтмал, газрын тосны газрын 128 нийтийн албан хаагчдын 2019 оны хөрөнгө орлогын мэдүүлэг, Нийтийн албанд шинээр томилогдох гэж буй иргэдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, нийтийн албанд шинээр томилогдсон албан хаагчдийн 2019 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргуулан холбогдох хууль, журмын дагуу Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах | Хууль, журамд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх Ашигт малтмал, газрын тосны газрын 2020-2022 оны батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахаар холбогдох нэгжүүдэд хүргүүлсэн. Тус төлөвлөгөөг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 1/546 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Төрийн захиргаа мөн төрийн үйлчилгээний удирдах болон гүйцэтгэх албан тушаалын 128 нийтийн албан хаагчийн 2019 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн зохион байгуулсан. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 26 /давхардсан тоогоор/ этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон бусад холбогдох материалыг хүлээн авч Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | |
| 3.2.1.4. Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг эрхлэн явуулах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулна. | 3.2.1.4.1. Улсын төсөвт 2020 онд нийт 159.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх, бүртгэх, биелэлтийг тайлагнах ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах | Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг биелүүлсэн эсэх<br>Бүтэн жилд: 159,2 тэрбум | АМГТГ-аас улсын төсөвт 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн байдлаар нийт 131.4 тэрбум төгрөг төвлөрүүлэн бүртгэж, тайлагнасан бөгөөд 2019 оны жилийн эцсийн 298.5 тэрбум төгрөг, 2020 оны 1-11 дүгээр сард нийт 130.6 тэрбум төгрөгийн дүнг Сангийн яамтай тооцоо нийлсэн. | |
| 3.2.1.5. Газрын тосны хайгуул, ашиглалтын өртөг нөхөгдөх зардалд хяналт тавих, газрын тостой холбоотой үйл ажиллагаанаас орох орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулна. | 3.2.1.5.1. Гэрээлэгчийн хийх ажлын төлөвлөгөө, төсвийг холбогдох хэлтсүүдтэй хамтран хэлэлцэж батлуулах, өртөг нөхөгдөх зардалд хяналт тавих, өртөг нөхөгдөх зардлын тайланг улирал бүр хүлээн авч, нэгтгэх | Төлөвлөгөө, төсөвт санал, дүгнэлт гарган ажилласан эсэх<br>Бүтэн жилд: 100% | • Бүтээгдэхүүн хуваах гэрээт 12 талбайн 2020 онд хийх ажлын нийт 466.7 сая ам.долларын төлөвлөгөө, төсөв батлагдсан.<br>• Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд 2019 оны 4 дүгээр улиралд 164.6 сая ам.доллар, 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 249.9 сая ам.доллар, 2020 оны 1 дүгээр улиралд 10.6 сая ам.доллар, 2 дугаар улиралд 12.3 сая ам.доллар, 3 дугаар улиралд 12.3 сая ам.долларын өртөг нөхөгдөх зардлын тайланг хүлээн авч нэгтгэсэн.<br>• Газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй гэрээлэгч компаниудын актлах шаардлагатай | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| | | | хөрөнгийн жагсаалтыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/32 дугаар тушаалаар шийдвэрлүүлсэн.<br>• “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 2019 оны үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн бөгөөд корона вирус цар тахлын улмаас улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбогдуулан Петрочайна Дачин Тамсаг ХХК-ийн 2019 оны үндсэн хөрөнгө болон бараа, материалын товчоо тайланг гаргуулан авсан.<br>• “Доншен газрын тос (Монгол)” ХХК-аас ирүүлсэн төлөвлөгөө, төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлтийг хянасан бөгөөд Гэрээлэгчийн Монголд ажиллах шаардлагатай ажиллагсадыг ногоон бүс хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад ирүүлэхтэй холбоотой зардал ба энэ нь нэгэнт гарсан зардал тул баримтад үндэслэх саналыг гэрээлэгчид хүргүүлсэн. | |
| | 3.2.1.5.2. Гэрээлэгчдийн бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх тусгай зөвшөөрлийн төлбөр, сургалтын урамшуулал, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг төлбөрийг Газрын тосны тухай хууль болон гэрээнд заасан хугацаа, талбайн хэмжээ зэргээс хамааруулан тухай бүр тооцож, нэхэмжлэн төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | Төлбөр, урамшууллыг тооцоолон нэхэмжлэл хүргүүлж, төлбөрийн хуваарилалтыг тооцон дүн мэдээг Сангийн яаманд сар бүр хүргүүлсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрүүлдэг төлбөр, урамшууллыг тооцож, нэхэмжилсэн ба гэрээлэгч компаниудад нийт 22 албан бичгийг хүргүүлсэн бөгөөд нийт (12-р сарын 7-ны байдлаар) 1.5 сая ам.долларыг төвлөрүүлсэн. Гэрээлэгчдийн 2019 оны 12 дугаар сараас 2020 оны 11 дүгээр сард төлсөн нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг улсын төсөв, орон нутагт хуваарилах тооцоог хийж, дүн мэдээг сар бүрийн 10-ны өдрийн дотор Сангийн яаманд 12/166, 4/699, 4/1189, 4/1623, 4/2078, 13/2733, 4/3150, 4/3521, 4/4025, 6/4672, 4/5174, 4/5421 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн. | |
| 3.2.2.1. Агентлагийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, | 3.2.2.1.1. УИХ, Засгийн газраас батлан гаргах тогтоолын төсөл, салбарын чиглэлээр мөрдөгдөж буй хууль бусад хууль тогтоомжийн төсөлд санал өгөх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: Ирүүлсэн төслийн /хуваарилагдсан/ тоогоор санал өгсөн байна. | Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тооцох, төлөх журам, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус тус санал өгч ажилласан. | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|
| батлуулах, мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина. | **3.2.2.1.2.** Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг сунгах, шилжүүлэх, барьцаалах, талбай буцаан өгөх зэрэг тусгай зөвшөөрлийн хөдөлгөөнтэй холбоотой Кадастрын хэлтсийн даргын шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах, өргөдлийн материалд холбогдох хууль тогтоомж, зааврын дагуу эрх зүйн шүүлт хийх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Нийт 1016 тусгай зөвшөөрлийн өргөдөл, дотоод хяналтын хуудсын материалд эрх зүйн шүүлт хийсэн байна. Үүнээс 354 тусгай зөвшөөрлийн өргөдөл, 662 дотоод хяналтын хуудсын материалд эрх зүйн шүүлт хийж ажилласан байна. | |
| | 3.2.2.1.3. Таван толгой-XXXIII” эрлийн талбайд нүүрсний давхаргын метан хийн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх Бүтээгдэхүүн хуваах гэрээг “Эрдэнэс Метан” ХХК-тай байгуулахад эрх зүйн дэмжлэг үзүүлэх | Холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 143 дугаар тогтоолын дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Х.Хэрлэн, “Эрдэнэс Метан” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Амар нар 2020 оны 5 дугаар сарын 6-ны өдөр ””Таван толгой-XXXIII” талбайд уламжлалт бус газрын тос болох нүүрсний давхаргын метан хийн үйл ажиллагаа явуулах бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурсан | |
| 3.2.3.1. Хууль тогтоомж, УИХ, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, агентлагийн үйл ажиллагааны болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний явц, Үндсэн чиглэлийн биелэлтийн тайлан зэрэгт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн УУХҮЯ-нд хүргүүлнэ. | 3.2.3.1.1. Хууль тогтоомж, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад батлагдсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд хүргүүлэх | Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж нь холбогдох журамд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Хууль тогтоомж, УИХ, ЗГ-ын тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөжмийг нэгжийн даргад танилцуулсан. | |
| | 3.2.3.1.2. Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэн ирүүлсэн Ашигт малтмал, газрын тосны газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах | Тайлангийн хэрэгжилтийн үр дүнд ахиц гарсан эсэх<br>Бүтэн жилд: 100% | Агентлагийн 2020 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг боловсруулан, нэгжийн даргад танилцуулсан. | |
| | 3.2.3.1.3. Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэн ирүүлсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтэд хагас жил, жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулах | Үнэлгээ, дүгнэлт, зөвлөмж нь холбогдох журамд нийцсэн эсэх<br>Бүтэн жилд: 100% | Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн тайланг буцааж, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгтгэн дүгнэж ирүүлэхийг мэдэгдсэн. ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг авч, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын дагуу хяналт- | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
| --- | --- | --- | --- | --- |
| | | | шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг боловсруулан, нэгжийн даргад танилцуулсан. Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, дүгнэлт зөвлөмжийг нэгжийн даргад танилцуулсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 82.5 хувиар үнэлэгдсэн. | |
| 3.2.3.2. Агентлагийн төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод аудит хийнэ. | 3.2.3.2.1. Агентлагийн төсвийн төлөвлөлт болон гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, бусад санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх | Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцсэн эсэх Бүтэн жилд: Аудитын үйл ажиллагааны дүгнэлт, санал, зөвлөмж гарган зөрчлийг арилгуулах арга хэмжээ авсан байна. | Агентлагийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ил тод байдлыг тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, байгууллагын дотоод журмын дагуу харилцах данс, бэлэн мөнгөний тайлан, дараа тайлан, шатахууны тооцоо, цалин, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үндсэн хөрөнгө, бараа материалын ерөнхий журнал болон анхан шатны материалыг тулган баталгаажуулсан. Дотоод аудитаар шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын барьцаа төлбөрийн буцаан олголт удаашралтай, он дамжсан авлагыг барагдуулаагүй байсныг аудитын дүгнэлтээр хугацаатай үүрэг даалгавар өгсөн. | |
| 3.2.3.3. Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудын холбогдох заалтын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | 3.2.3.3.1. Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулиудын холбогдох заалтын дагуу байгууллагын шилэн дансны хөтлөлтөд хяналт тавьж ажиллана. | Холбогдох хууль журмын дагуу хянасан эсэх Бүтэн жилд: 100% | Шилэн дансны тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг тогтмол хянаж, шилэн дансанд 5 саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, хүний нөөцийн мэдээлэл, Ашиг сонирхолын мэдүүлгийг цаг хугацаанд нь байршуулан ажиллаж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан. | |

**ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР:**

**УУХҮЯ –** Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
**УУХҮ-ийн сайд –** Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд
**АМГТГ-** Ашигт малтмал, газрын тосны газар
**ЭБМЗ-** Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл
**ТЗУХ-** Төрийн захиргааны удирдлагын хэлтэс
**ГХХ-** Геологи, хайгуулын хэлтэс
**УУҮТХ-** Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтэс
**НСХ-** Нүүрсний судалгааны хэлтэс

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|

**КХ-** Кадастрын хэлтэс
**ХЭЗХ-** Хууль, эрхзүйн хэлтэс
**ГТАХ-** Газрын тосны ашиглалтын хэлтэс
**ГТБХ-** Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс
**ХШҮСХ-** Хяналт-шинжилгээ, статистикийн хэлтэс
**ХҮТТХ-** Хүнд үйлдвэрийн техник технологийн хэлтэс
**УУГТТЛ-** Уул уурхай, газрын тосны төв лаборатори
**ЗГҮАХ-** Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
**ЗГҮАХХАХТ-** Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
**АМТХ-** Ашигт малтмалын тухай хууль
**ТЭБСББ-** Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого
**ЭЗНХҮЧ-** Монгол улсын Эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
**ТГТСХТББ-**Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого /2018-2027/
ҮГА- Үндэсний геологийн алба

Ашигт малтмал, газрын тосны газрын дарга ……………………… /Х.Хэрлэн/

*2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр*

| 1 | 2 | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|